



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/03

Зуунмод

Г Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн^Г
үед авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5. “в”, 29.1.6 “а”, “ж”, “л”, 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.4 заалт, 11 дүгээр зүйлийн 11.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-ийн үед дараах арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлсүгэй.

1.1. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн хугацаанд аймгийн хэмжээнд олон нийтийг хамруулан нэг дор цуглуулах хэлбэрээр зохион байгуулах хурал, сургалт, жагсаал, цуглаан, аялал зугаалга, тэмцээн уралдаан, хурим найр, цайллага, хүлээн авалтыг хориглосугай.

1.2. Дараахь салбаруудад цахим болон зайны хэлбэрээр явуулахаас бусад үйл ажиллагааг хориглосугай.

- а. урлаг соёл, үзвэр үйлчилгээ
- б. спортын арга хэмжээ /заал, бильярд, фитнес, бүжиг, иог/
- в. өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа
- г. цахим болон бүх төрлийн тоглоомын үйлчилгээ
- д. шашны зан үйл /гандан, сүм хийд, мөргөлийн газар/
- е. бүх төрлийн баар /диско, караоке, паб/
- ё. нийтийн халуун усны газар, саун
- ж. бариа засал, массажны газар, гоо сайхны үйлчилгээ /маникур, педикур, шивээс/

з. амралт, жуулчны бааз, зочид буудал, дэн буудал

1.3. Энэ захирамжаар хориглосноос бусад худалдаа, үйлчилгээ, ресторан, кафе, нийтийн хоолны газруудын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг 08:00-22:00 цаг хүртэл, банк санхүү, харилцаа холбоо, үүрэн телефоны байгууллагын үйлчлэх цагийн хуваарийг 09:00-18:00 цаг хүртэл тогтоож, согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд 18 хувь хүртэлх спиртийн агууламжтай согтууруулах ундаа худалдан борлуулахыг зөвшөөрсүгэй.

1.4. Үйл ажиллагааг хязгаарласан, хориглосноос бусад аж ахуйн нэгж байгууллагуудад ажил үйлчилгээ явуулахдаа насанд хүрээгүй хүн болон амны хаалтгүй

хүнд үйлчлэхгүй байх, иргэдийн халууныг хэмжиж, QR кодоор бүртгэл хийж нэвтрүүлэх, ариутгал халдваргүйтгэл, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж, хүн хоорондын зайг бариулж ажиллахыг үүрэг болгож, энэ журмыг зөрчсөн аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /У.Өлзийцэцэг/-т даалгасугай.

1.5. Аймаг, сум хоорондын хяналтын цэгүүдээр дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийг сумын төвд зогсоолгүй зорчуулах, голомттой бүс нутгаас аймаг, суманд ирж буй иргэдээс түргэвчилсэн /тухайн өдрийх/ болон PCR шинжилгээний /шинжилгээний хариу гарснаас хойш 48 цагийн дотор зорчих/ хариуг шаардах, цаашлаад 14 хоног гэрийн тусгаарлалтад байлган хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар /С.Мөнхтуяа/, Мэргэжлийн хяналтын газар /У.Өлзийцэцэг/, Цагдаагийн газар /Б.Ганзориг/, бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

1.6. Зуунмод сумаас орох, гарах хөдөлгөөнийг хянах Өндөр дов, Лүн, Баян, Баянчандмань сумдын авто замын хяналтын цэгүүдэд Мэргэжлийн хяналтын газрын байцаагч нарыг байлгаж нэмэлтээр Цагдаагийн газар, Онцгой байдлын газрын албан хаагчдыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн хугацаанд үүрэг гүйцэтгүүлэн орох, гарах хөдөлгөөнд асуумж судалгаа, авч хяналтыг өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын газар /Н.Төмөрбаатар/, Цагдаагийн газар /Б.Ганзориг/, Мэргэжлийн хяналтын газар /У.Өлзийцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.

1.7. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настанд хүнс тэжээл, түлээ нүүрс, бусад дэмжлэг туслалцаа үзүүлж шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт, уг арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /Д.Батцэцэг/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Д.Бадамцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.

1.8. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед бараа, үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байхыг аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч нарт, өдөр тутмын хяналтыг зохион байгуулж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /У.Өлзийцэцэг/-т үүрэг болгосугай.

1.9. Зуунмод суманд үйлчлэх такси үйлчилгээг халдвар хамгааллын зөвлөмжийн дагуу автомашины ариутгал, жолооч болон иргэд халдвараас урьдчилан сэргийлэх, амны хаалтыг зүүх, гар халдваргүйжүүлэгчийг тогтмол байршуулах, жолоочоос гадна 3-аас илүүгүй хүн тээвэрлэх, нийтийн тээврийн үйл ажиллагааг Зүүндэлгэр, Баянхошуу чиглэлд богиносгосон цагаар иргэд хоорондын зайг бариулан халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулж хөдөлгөөнд оролцуулахыг Авто тээврийн төв /Н.Аасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /У.Өлзийцэцэг/-т тус тус даалгасугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Сурмаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР